

Хөдөлмөрийн гэрээ түүний төрлүүд

Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч
М.Үүрийнтуяа

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын эргэн тойронд

Шинээр бий болж буй ажлын байрны онцлог, ажилтан ажил олгогчийн хооронд үүсч буй эрх зүйн харилцааг зөв тодорхойлж, тохирсон гэрээг байгуулах нь талуудын эрхийг тэнцвэртэй хамгаалах, тэдний хоорондын харилцааг хуулийн дагуу, үр өгөөжтэй зохицуулах, үүдэн гарах аливаа зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.




Шинэчилсэн
найруулга
2021 оны 07 сарын 02
батлагдсан.
2022 оны 1 дүгээр
сарын 1-ний өдрөөс
эхлэн дагаж мөрдөж
байна.



Асар хурдацтай хөгжиж буй харилцаа холбоо, техник технологийн дэвшил хийгээд сүүлийн жилд тархаад буй цартахлын нөлөө нь уламжлалт хөдөлмөрийн харилцааны хэв маягийг илүү уян хатан, цаг хугацаа орон зайны хамаарал, хязгаарлалт багатай хэв маягт шилжих боломжийг олгож байна.


ӨНӨӨДРИЙН ХИЧЭЭЛИЙН зорилго, ямар агуулгын хүрээнд вэ?



Хөдөлмөрийн гэрээ
түүний төрлүүдийн
зорилго,
зохицуулалт,
онцлогийг
нарийвчлан авч
үзье.

Байнгын ажлын байр гэдгийг ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил, үүрэг хэмээн Хөдөлмөрийн тухай хуульд тодорхойлсон.

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ



Хөдөлмөрийн гэрээ, түүний талууд

Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээ байгуулна.

- Ажил олгогч хөдөлмөрийн гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр үйлдэж талууд гарын үсэг зурах бөгөөд гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй.

- Хөдөлмөрийн гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр үйлдээгүйгээс үл хамааран ажилтан ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээр хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүссэнд тооцно.



Хүндэтгэн үзэх шалтгаанаар хөдөлмөрийн гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр үйлдээгүй бол ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээс хойш ажил олгогч ажлын 10 өдрийн дотор хөдөлмөрийн гэрээг нөхөн байгуулах үүрэгтэй.



Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана:


- ✓ Ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг;
- ✓ Ажил үүрэг гүйцэтгэх байршил;
- ✓ Цалин хөлсний хэмжээ;
- ✓ Хөдөлмөрийн нөхцөл.

Хөдөлмөрийн гэрээг хугацаатай байгуулах тохиолдол

- ❖ Дагалднаар ажиллуулах
- ❖ Туршилтын хугацаагаар ажиллуулах
- ❖ Улирлын шинжтэй ажил гүйцэтгүүлэх
- ❖ Ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд ажиллуулах
- ❖ Түр ажлын байранд ажиллуулах
- ❖ Санхүүжилт, хийгдэх ажлын цар хүрээтэй холбоотой цаг хугацаагаар хязгаарлагдсан ажил үүрэг гүйцэтгүүлэх

Хөдөлмөрийн гэрээний төрөл

1. Дагалднаар ажиллах хөдөлмөрийн гэрээ
2. Дагалднаар суралцах хөдөлмөрийн гэрээ
3. Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ
4. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ /Контракт/
5. Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ
6. Гэрээсээ ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ
7. Зайнаас ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ



**Дагалднаар ажиллах
хөдөлмөрийн гэрээ**

Зорилго: Дадлага, ур чадвар

Хугацаа: 3 сар + 3 сараас илүүгүй

Нарийн мэргэжил: 2 жил + 1 жилээс
илүүгүй

Цалин: Үндсэн цалингийн 70 хувиас
дээш

*Дагалднаар ажилласан
ажилтантай туршилтаар
ажиллуулах хөдөлмөрийн гэрээ
байгуулахгүй.*

**Дагалднаар суралцах
хөдөлмөрийн гэрээ**

Зорилго: Онолын мэдлэгийг практик
дадлагатай хослуулах, ажлын
дадлага, ур чадвар эзэмшүүлэх

НДШ: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
сангаас төлнө.

Хугацаа: Суралцах мэргэжлээс
шалтгаалан гурав хүртэл жил

Цалин: Хөдөлмөрийн хөлсний доод
хэмжээнээс доошгүй

Туршилтаар ажиллах хөдөлмөрийн гэрээ

Зорилго: Тухайн ажлын айранд тэнцэх эсэхийг шалгах

Хугацаа: 3 сар + 3 сараас илүүгүй

Цалин: Үндсэн цалингаас багагүй

Улирлын шинжтэй ажлыг нэг удаа гүйцэтгүүлэх, ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд, эсхүл түр ажлын байранд ажиллуулах тохиолдолд ажилтантай туршилтаар ажиллуулах гэрээ байгуулахгүй.

Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруугаас ажил олгогчид учруулсан эд хөрөнгийн хохирлыг Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 131 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд зургаан сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээгээр хариуцан арилгах үүрэгтэй.

Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ

- ❖ Өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд нь өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг ажилтнаар дамжуулан хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлагын түвшний ажил үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор тухайн ажилтантай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
- ❖ Онцгой нөхцөл бүхий гэрээнд ажлын эцсийн үр дүн, дүгнэх журам Урамшуулал, хангамж, хөнгөлөлт, хувь зэргийг тусгаж болно.

Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ

- ❖ Ажлын бүтэн цагаар ажиллаж байгаа ажилтнаас бага цагаар ажиллаж байгаа ажилтны ойлгоно.
- ❖ Энэхүү гэрээнд ажиллах өдөр, цаг, ажил эхлэх, дуусах хугацаа зэргийг тусгана.
- ❖ Ажил олгогч түр ажил үүргийг гүйцэтгүүлэхээр ажилтныг цагаар ажиллуулж, гүйцэтгэсэн ажил, ажилласан цагт нь тохирсон цалин хөлсийг тухай бүр тооцож олгож болно.
- ❖ Ажлын бүтэн цагийн ажилтны ажлын цагийг хууль тогтоомжид заасны дагуу богиносгосныг бүтэн бус цагаар ажилласанд тооцохгүй.

Гэрээсээ ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ

- ❖ Ажилтан ажил олгогчийн үйл ажиллагаа явуулдгаас өөр газарт, гэрээсээ, эсхүл өөрийн сонгосон байршилд ажил олгогчийн, эсхүл өөрийн тоног төхөөрөмж, түүхий эд материалыг ашиглан ажил олгогчийн удирдлага, хяналтын доор ажил үүрэг гүйцэтгэж цалин хөлс авахаар ажил олгогчтой тохиролцон гэрээсээ ажиллах хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
- ❖ Энэхүү гэрээнд ажилтан ажил үүргээ гүйцэтгэх байршил, гүйцэтгэх ажил, гүйцэтгэсэн ажлаа хүлээлгэн өгөх хугацаа, хэлбэр, цалин хөлс, үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүн, үзүүлсэн нэгж үйлчилгээний төлбөр /тариф/, өөрийн эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг ашигласан тохиолдолд ажил олгогчоос олгох нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг талууд тусгайлан тохиролцож тусгана.
- ❖ Гэрээсээ ажиллах ажилтны ашиглах тоног төхөөрөмж, бусад хэрэгслийн аюулгүй байдлыг ажил олгогч шалгаж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх үүрэгтэй.
- ❖ Гэрээсээ ажиллах ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн Ажил, амралтын цагтай холбоотой бүлгийн зохицуулалт үйлчлэхгүй.

Зайнаас ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ

- ❖ Ажил олгогч нь ажилтныг ажил үүргээ зайнаас цахим сүлжээгээр байнга, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэхийг зөвшөөрч, түүнтэй зайнаас ажиллуулахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
- ❖ Зайнаас ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээнд ажилтан ажил үүргээ гүйцэтгэх байршил, гүйцэтгэсэн ажлаа хүлээлгэн өгөх хугацаа, хэлбэр, өөрийн эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг ашигласан тохиолдолд ажил олгогчоос олгох нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг талууд тусгайлан тохиролцож тусгана.

Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулах

Ажилтан үндсэн ажил олгогчтой онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан;

Үндсэн ажил олгогчтой ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, эсхүл зах зээлд өрсөлддөг аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах бол;

Хүн амын аюулгүй байдал, эрүүл мэнд, тав тухтай орчинд амьдрах эрхийг хангахтай холбоотой ажил үүрэг гүйцэтгэдэг бол.
(Төмөр зам-Удирдах)



**АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**